



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/660

Булган сум

### Зорилтот өрхийн ахмад настнуудад түлшний дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахмад настнуудад нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг хүргэх, амьжиргааг дэмжих, өвөлжилтийн бэлэн байдлыг хангах зорилгоор нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй ахмад настнуудад түлшний дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Ахмад настнуудад түлш бэлтгэн, нийлүүлэх гэрээ байгуулан, түлээ олгох ажлыг шуурхай зохион байгуулж, ажиллахыг Булган суман дахь Сум дундын ойн ангийн дарга (Б.Алтансүх), гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах) нарт даалгасугай.

3. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийн 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Ахмад настны хөгжил хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас, 10,000,000 (арван сая) төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас тус тус санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010923

Сүхрэг Ажил 2025 өдөр бүр 000/2025/Захирамж